



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/08/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт хот
2023 он

Дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123
Аудитор: О.Барчидгүнсэн
Утас: 70512123

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Материаллаг байдал	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.5.1 Завсрын аудитын талаар.....	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
5.1 Албан шаардлага	12
5.2 Зөвлөмж.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмч аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.03.22 № 156
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР
ХӨГЖИЛ ҮТП ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
О.БАТСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар хөгжил ҮТП ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Сүхбаатар хөгжил ҮТП” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дотор хэрэгцээнд байгууллагын захирал өөрийн эзэмшлийн авто тээврийн хэрэгслийг ашиглаж түлш шатахуун зарцуулжээ.

Аудитын гол асуудал

“Сүхбаатар хөгжил ҮТП” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлангаар олон жил дамжсан ер төлбөртэй, түрээсийн орлого 19.0 сая төгрөгийн орлогоос өөр орлого эх үүсвэр байхгүй орон нутгийн төсвөөс 46.0 сая төгрөгийн дэмжлэг авч 73.8 сая төгрөгийн алдагдалтай үйл ажиллагаа явуулсан.

Бусад асуудлын хэсэг

“Сүхбаатар хөгжил ҮТП” ОНӨААТҮГ-ын 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Аймгийн ИТХ-аар батлуулахаар хүргүүлсэн боловч батлаагүй бөгөөд үр дүнг нь дүгнээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	797,838,072.60	689,121,288.01
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	73,707,115.70	84,795,277.09
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	1,379,888.23	1,596,337.41
31110	Төгрөг	1,379,888.23	1,596,337.41
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	72,327,227.47	83,198,939.68
31210	Төгрөг	72,327,227.47	83,198,939.68
31213	Арилжааны банк дахь харилцах	72,327,227.47	83,198,939.68
33	АВЛАГА	704,400,378.33	577,764,014.16
33401	Дансны авлага /ТӨҮГ/	693,584,778.06	564,991,965.33
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	10,815,600.27	12,772,048.83
35	БАРАА МАТЕРИАЛ	19,730,578.57	26,561,996.76
35400	Хангамжийн материал	19,730,578.57	26,561,996.76
35470	Бусад хангамжийн материал	19,730,578.57	26,561,996.76
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	675,887,593.91	641,224,967.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	675,887,593.91	641,224,967.75
39200	Биет хөрөнгө	580,561,193.91	545,898,567.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	670,972,798.69	670,972,798.69
39202	Хуримтлагдсан элэгдэл	-99,855,558.07	-136,865,462.71
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	11,074,400.00	7,300,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-9,266,915.99	-2,096,159.83
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,290,416.00	11,290,416.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,653,946.72	-4,703,024.40
39300	Биет бус хөрөнгө	95,326,400.00	95,326,400.00
39303	Бусад биет бус хөрөнгө	95,326,400.00	95,326,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,473,725,666.51	1,330,346,255.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,680,128,359.04	1,610,571,724.05
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,680,128,359.04	1,610,571,724.05
41200	Богино хугацаат зээлийн өглөг	959,940,404.03	884,284,120.92
41210	Төгрөг	959,940,404.03	884,284,120.92
41214	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	959,940,404.03	884,284,120.92
41300	Өглөг	43,548,988.68	49,648,636.80
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	37,394.00	37,394.00
41360	Бусад өглөг	43,511,594.68	49,611,242.80
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	3,654,557.32	7,682,245.44
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	39,857,037.36	41,928,997.36
41400	Урьдчилж орсон орлого	676,638,966.33	676,638,966.33
41450	Төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн газар	676,638,966.33	676,638,966.33
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-206,402,692.53	-280,225,468.29
51	Засгийн газрын хувь оролцоо	-206,402,692.53	-280,225,468.29
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	95,326,400.00	95,326,400.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-301,729,092.53	-375,551,868.29
51210	Өмнөх үеийн үр дүн	-236,860,565.28	-301,729,092.53
51220	Тайлант үеийн үр дүн	-64,868,527.25	-73,822,775.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,473,725,666.51	1,330,346,255.76

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	74,705,373.29	66,780,781.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,705,373.29	66,780,781.17
120	Нийтлэг татварын бус орлого	74,705,373.29	66,780,781.17
120002	Хүүгийн орлого	2,355,440.16	538,281.17
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	51,859,101.10	47,230,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,859,101.10	46,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0	1,230,000.00
120005	Түрээсийн орлого	20,490,832.03	19,012,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	139,573,900.54	140,603,556.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	139,573,900.54	140,603,556.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	139,573,900.54	140,603,556.93
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	139,573,900.54	140,603,556.93
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	139,573,900.54	140,603,556.93
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-64,868,527.25	-73,822,775.76
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-64,868,527.25	-73,822,775.76

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,326,400.00		-236,860,565.28	-141,534,165.28
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,326,400.00		-236,860,565.28	-141,534,165.28
9	Тайлант үеийн үр дүн			-64,868,527.25	-64,868,527.25
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,326,400.00		-301,729,092.53	-206,402,692.53
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	95,326,400.00		-301,729,092.53	-206,402,692.53
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0		0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,326,400.00		-301,729,092.53	-206,402,692.53
19	Тайлант үеийн үр дүн	0		-73,822,775.76	-73,822,775.76
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	95,326,400.00	0	-375,551,868.29	-280,225,468.29

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	300,905,605.45	248,644,562.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	300,905,605.45	248,644,562.19
120	Нийтлэг татварын бус орлого	300,905,605.45	248,644,562.19

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,785,000.00	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,785,000.00	0
120009	Бусад орлого	0	58,325,500.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	296,120,605.45	144,319,062.19
120017	Татаас, санхүүжилтийн орлого /ТӨҮГ/	0	46,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	238,192,001.29	236,201,244.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	238,192,001.29	236,201,244.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	238,192,001.29	236,201,244.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	49,630,850.62	48,301,113.04
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	49,630,850.62	48,301,113.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,331,593.59	15,173,655.61
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	13,331,593.59	15,173,655.61
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175,229,557.08	172,726,475.66
210815	Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	3,052,293.17	2,255,159.09
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	11,088,332.68	244,010.82
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	161,088,931.23	170,227,305.75
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	62,713,604.16	12,443,317.88
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	7,679,816.87	2,153,124.68
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт	7,066,320.48	1,614,843.51
140007	Хүлээн авсан хүүний орлого	613,496.39	538,281.17
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,785,000.00	2,970,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,785,000.00	2,970,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,785,000.00	2,970,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,785,000.00	2,970,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	2,894,816.87	-816,875.32
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-413,496.39	-538,281.17
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	413,496.39	538,281.17
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	413,496.39	538,281.17
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	65,194,924.64	11,088,161.39
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,512,191.06	73,707,115.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	73,707,115.70	84,795,277.09

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

"Шинэ дэвшилтэт технологиор өрхийн болоод импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжин бүсчлэн хөгжүүлнэ. Ажлын байрыг нэмэгдүүлж орон нутгийн хөгжлийн тулгуур төв болно" гэж зорилгоо тодорхойлж, дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Зорилт:

- Үйлдвэрлэл технологийн бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх
- Дэд бүтэц, барилга байгууламжийг барьж байгуулах, бизнесийн таатай орчин бүрдүүлэх
- Хөрөнгө оруулагчдыг татах, хамтын ажиллагааг идэвхжүүлэх
- Хүн амын эрүүл мэндийг дэмжсэн хүнсний бүтээгдэхүүн, эмийн ургамал, эко тариалалтыг хөгжүүлэх
- ҮТП-н хүний нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, хөгжүүлэх
- Шинэ дэвшилтэт технологи нутагшуулах, инновацыг дэмжих
- Өрхийн орлогыг дэмжих төсөл, хөтөлбөрийг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрийг чадавхжуулах
- Төмөр замын худалдааны төв зангилаа бүс, дотоод, гадаад худалдааг дэмжсэн тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагаа явуулах статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

Тухай байгууллага тайлант онд түрээсийн 19,012.5 мянган төгрөгийн орлого олж, орон нутгийн төсвөөс 46,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, 73,822.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 05 сарын 19-ны 36 тоот тогтоолоор "Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /ААТҮГ/ нэртэйгээр байгуулагдаж, 2017 оны 06 сарын 06-ны өдрөөс үйл ажиллагаа эхэлсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлд " орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих " гэсэн заалттай нийцэж байна.

Тайлант хугацаанд байгууллагыг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн*, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 143,379.5 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар *буурсан* байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	73,107.1	84,795.2	11,088.1
Авлага	693,584.8	564,991.9	-128,592.9
Татвар НДШ-ийн авлага	10,815.6	12,772.1	1,956.5
Бараа материал	19,730.5	26,561.9	6,831.4
Үндсэн хөрөнгө	675,887.6	641,225.0	-34,662.6
Нийт хөрөнгө	1,473,725.6	1,330,346.1	-143,379.5
Өр төлбөр	43,548.9	49,648.5	6,099.6
Урт хугацаат зээл	959,940.4	884,284.1	-75,656.3
УОО	676,638.9	676,638.9	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	95,326.4	95,326.4	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,473,725.6	1,330,346.1	-143,379.5

Арилжааны банкин дахь харилцах дансанд үлдэгдэл 84,795.2 мянган төгрөг болж 11,088.1 мянган төгрөгөөр өссөн нь жижиг дундын үйлдвэрлэлийн санд хүүгийн орлого орж ирснээс шалтгаалсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 564,991.9 мянган төгрөг болж өмнөх оноос 128,592.9 мянган төгрөгөөр буурсан нь жижиг дундын үйлдвэрлэлийн сангийн зээл болон хүүгийн орлого орж ирсэн, НӨАТ-ын авлага 1,956.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Авлагын дансны үлдэгдэл 2018-2021 онд үүссэн зээл болон зээлийн хүүгийн авлага 564,991.9 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 6,831.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Хангамжийн материал худалдан авсан нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 641,225.0 мянган төгрөг болж өмнөх оноос 34,662.6 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө данснаас хассан, мөн элэгдлийн зардал нөлөөлжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 49,648.5 мянган төгрөг болж 6,099.6 мянган төгрөгөөр өссөн нь орлого дутуу төвлөрч ус дулаан, татварын өр үүссэн байна.

Урт хугацаат зээлийн дансны үлдэгдэл 884,284.1 мянган төгрөг болж 75,656.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд жижиг дундын үйлдвэрлэлийн сангийн зээл болон хүүгийн төлбөр төлөгдсөн нөлөөлжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ нь 2022 онд Аймгийн засаг даргатай контрактын гэрээ байгуулаагүй ажиллажээ.

2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталууллаагүй байна. Тайлант оны нийт орлогыг 137,680.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 82,147.0 мянган төгрөгөөр, 49,980.0 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр түрээсийн орлого 19,012.5 мянга, бусад орлого /зээлийн алданги/ 1,768.2 мянга, орон нутгийн санхүүжилт 46,000.0 мянга, нийт 66,780.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 140,603.5 мянган төгрөгийн зардал гарган, 73,822.8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 20,780.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 116,899.0 мянган төгрөг буюу 94.4 хувиар тасарсан нь 2018-2021 оны хугацаанд олгосон зээлийг хугацаандаа төлөөгүй ААНБ, хувь хүмүүсийн хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн. Үүнтэй холбогдуулан шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газраар гүйцэтгэл хийлгэхтэй холбоотой зээлийн алданги орохоор төлөвлөсөн, түрээсийн төлбөрийн төлөвлөлттэй холбоотой тасарсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 140,603.5 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 58,456.5 мянган төгрөг буюу 58.5 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь элэгдлийн зардал 38,862.6 мянган төгрөг гол нөлөө үзүүлсэн байна.

Тус байгууллага 2022 онд зорилтот түвшин, үйл ажиллагааны төлөвлөгөө, ашиг орлогын хуваарилалт, бусад эх үүсвэрийг батлуулахаар зохих шатны байгууллагад хүргүүлсэн боловч батлаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ОНӨААТҮГ-ийн үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлантай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Барчидгүнсэн, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлаас 140,603.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,109.0 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд 1,840.0 мянган төгрөгөөр өссөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант оны өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8² заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх зөвлөмж өгсөн.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл технологийн парк ОНӨААТҮГ нь завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	6,935.0		2	6,935.0
Зөвлөмж	1	0.0		1	0.0
Нийт дүн	3	6,935.0		3	6,935.0

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4 зөрчил³ илэрснээс алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 албан шаардлага 3 зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

Дотор хэрэгцээнд байгууллагын захирал өөрийн эзэмшлийн авто тээврийн хэрэгслийг ашиглаж 5,624.7 мянган төгрөгийн түлш шатахуун зарцуулжээ Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 /Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно/ заалтыг зөрчсөнд албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр олгосон зээл, зээлийн хүүгийн авлага аймгийн төрийн санд төлөх сангийн өр төлбөртэй материаллаг зөрүүтэй илэрхийлэгдсэн байгаа бөгөөд үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5./дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 /хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх/ заалттай нийцэхгүй байна.

³ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.1 Үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

5.1.1 Цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 /Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно./ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 / үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох;/ дахь заалтыг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж:

Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулах асуудлыг эрх бүхий байгууллагад хүргүүлэн, шийдвэрлүүлэх

Илрүүлэлт:

5.1.2 Тээвэр шатахууны зарцуулалтад замын хуудсыг бүрэн, тодорхой, иж бүрэн хөтлөөгүй, зөрчил илэрлээ. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тээвэр шатахууны зарцуулалтад замын хуудсыг бүрэн, тодорхой, иж бүрэн хөтлөх

5.1 Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

5.1.3 Шилэн дансны цахим системд тайлант оны өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг мэдээлээгүй, мөн бусад мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8⁴ заасныг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж:

Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

⁴ бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулаагүй байна	1	0					1	0				
Дотор хэрэгцээнд байгууллагын захирал өөрийн эзэмшлийн авто тээврийн хэрэгслийг ашиглаж түлш шатахуун зарцуулжээ.	1	5624.7			1	5624.7						
Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр олгосон зээл, зээлийн хүүгийн авлага аймгийн төрийн санд төлөх сангийн өр төлбөртэй материаллаг зөрүүтэй илэрхийлэгдсэн байгаа бөгөөд үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулагдсан байна.	1	0			1	0						
Тээвэр шатахууны зарцуулалтад замын хуудсыг бүрэн, тодорхой, иж бүрэн хөтлөөгүй байна.	1	0					1	0				
Дүн	4	5624.7			2	5624.7	2	0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээллэсэн	1	0					1	0
Дүн	1	0					1	0